



Монгол улс: Институцийн өөрчлөлт хийх замаар эрдэс баялгийн менежментийг сайжруулах нь (MERIT) төсөл нь Канадын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр 2016 оноос 2023 он хүртэл хэрэгжинэ.

Тус төслийн зорилго нь төрийн байгууллагуудын менежментийг сайжруулах замаар Монгол Улсын олборлох салбарын нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд оруулж буй хувь нэмрийг нэмэгдүүлэх явдал юм.

Монгол Улс дахь техникийн зөвлөхүүд болон MERIT төслийн багийн дэмжлэгтэйгээр энэхүү төслийг Канадын Мэргэжлийн Үйлчилгээний байгууллага болон Канадын их дээд сургуулийн үйлчилгээ гэх хоёр төрийн бус байгууллагын консорциум хэрэгжүүлж байна.

СЕСМИМ төслийн багтай хамтран хэрэгжүүлж буй энэхүү “Мэдлэгийн портал”-д ГГХ-ийн нээлттэй мэдээллүүдээс гадна MERIT төслийн хүрээнд авч хэрэгжүүлж буй бүх төрлийн сургалтын материал, холбогдох гарын авлага, мэдээ мэдээллүүдийг нээлттэй байршуулах болно.



www.portal.merit.mn
www.merit.mn



Монгол Улсын Олборлох салбарын менежментийг бэхжүүлэх (СЕСМИМ) төсөл нь Канадын Гадаад хэргийн яамны санхүүжилтээр 2015 оноос 2020 он хүртэл хэрэгжинэ.

Тус төслийн зорилго нь Монгол Улсын олборлох салбарын засаглалыг сайжруулах, Монгол Улсын өнөөгийн болон хойч үед тухайн салбарын үр ашгийг илүү тэгш хуваарилах бодлогыг дэмжсэн техникийн туслалцаа үзүүлэх явдал юм.

Төслийн хүрээнд Канадад туршлага судлах аялал, дадлагажих хөтөлбөр, сургалт семинар зохион байгуулах замаар Монгол Улсын төрийн болон төрийн бус байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, Канадын тэргүүн туршлагыг Монголд таниулах зэрэг төлөвлөсөн үйл ажиллагааг авч хэрэгжүүлж байна.

СЕСМИМ нь Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн хүсэлтээр “Мэдлэгийн портал” хөгжүүлэх, цаашид тогтвортой ажиллуулах талаар хоёр жилийн хугацаанд мэргэжил арга зүй болон санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. Мөн СЕСМИМ төслийн хүрээнд авч хэрэгжүүлж буй бүх төрлийн үйл ажиллагааны талаарх мэдээ, мэдээллийг нээлттэй байршуулах болно.



www.portal.sesmim.mn
www.sesmim.mn



МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ
УХААНЫ АКАДЕМИ



ШУА-ИЙН
ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН
ХҮРЭЭЛЭН

МЭДЛЭГИЙН ПОРТАЛ



ШУА-ИЙН ГАЗАРЗҮЙ-ГЕОЭКОЛОГИЙН ХҮРЭЭЛЭН

Эрхэм зорилго

Хүрээлэнгийн эрхэм зорилго нь байгаль орчин, нийгэм, эдийн засгийн төлөв байдлыг судлан, тэдгээр салбаруудад мэдлэгийн менежмент, инновацийг нэвтрүүлэх замаар Монгол улсын тогтвортой хөгжлийг хангахад хувь нэмэр оруулахад оршино.

Бидний зорилт

- Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Ногоон хөгжлийн бодлого, Шинжлэх ухаан, технологийг хөгжүүлэх тэргүүлэх чиглэл, цөм технологид нийцсэн судалгааг гүйцэтгэх;
- Бүтээмжийг нэмэгдүүлэх, шинийг сэдэх, аливааг сайжруулах боломжийг цаг ямагт эрэлхийлэн, шинэ санаа, инноваци, бүтээлч хандлагыг хөхүүлэн дэмжих;
- Судлаач бүр хөгжих, ахиж дэвших орчныг бүрдүүлж, хүний нөөцийн хөгжлийг байнга хангах;
- Эрдэмтдийн “Ахмад-Идэр-Залуу” гурван үеийн хэлхээс, мэдлэгийн холбоог дэмжин хөгжүүлэх;



МЭДЛЭГИЙН ПОРТАЛЫН ТӨСЛИЙН ТУХАЙ

Мэдлэгийн портал төсөл нь MERIT болон CECMIM төслийн дэмжлэгээр Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн бүх төрлийн мэдээ, мэдээлэл, судалгаа шинжилгээний ажлын үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй болгохыг зорьсон.

Төслийн хүрээнд Мэдлэгийн вэб портал хөгжүүлэх, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн судлаач нарыг сургалтанд хамруулан мэдлэгийн порталын талаар мэдлэг олгох болон мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх зэрэг үйл ажиллагааг авч хэрэгжүүлсэн.

Мэдлэгийн портал нь Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн “Нэг цэгийн мэдээ, мэдээллийн сан” байхаас гадна MERIT, CECMIM төслийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг багтаасан байна.



www.portal.igg.ac.mn
www.igg.ac.mn



ЯАГААД БИДЭНД МЭДЛЭГИЙН ПОРТАЛ ХЭРЭГТЭЙ ВЭ?



Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн салбар хоорондын хамтын ажиллагааны нэг цэгийн мэдээллийн эх сурвалжийг бий болгох



Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдын судалгааны ажлын үр дүнг агуулсан нэгдсэн сан үүсгэх



Эрдэмтэн судлаачдын ажлын үр дүн, бүтээл зэргийг хүмүүст илүү ойртуулж, хамрах хүрээ, хүртээмжийг нэмэгдүүлэх, сурталчлан таниулах



Монгол, Англи хэл дээр бэлтгэсэн илтгэл, сургалтын дүрс бичлэг, аудио болон нийлмэл контент, зурган мэдээллийг нийтлэх